

ЗАЛУУ СУДЛААЧДЫН БҮТЭЭЛД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ ДҮГНЭЛТ

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), профессор, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн

Түлхүүр үг: сэтгүүл зүй, судлал шүүмжлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл

МСНЭ-ээс эрхлэн гаргаж буй "Монголын шилдэг" нийтлэлийн 99 ботид багтсан сэтгүүл зүйн судалгааны гурван номын нэг болох сэтгүүл зүйн залуу судлаачдын бүтээлүүдийн эмхэтгэлийг амтархан уншлаа. Уншаад гурван зүйлийг ихээхэн олзуурхан тэмдэглэхийг хүсч байна. Нэгдүгээрт, орчин үеийн Монголын сэтгүүл зүйн судлаачдын залуу халаа бий болж, судалгааны өөрийн гэсэн арга барил, дуу хоолой, өнгө төрх, үзэл бодол, сэтгэлгээ мэдрэмж, хүсэл зорилготой залуу судлаачдын эгнээ өргөжсөнийг олж харлаа. Хоёрдугаарт, сүүлийн жилүүдэд сэтгүүл зүйн судалгааны сэдвийн хүрээ мэдэгдэхүйц өргөжиж, ерөнхийгөөс нэгж руу шилжиж, харьцангуй бага судлагдсан асуудлуудыг сонгон авч, олон талаас нь гүнзгийрүүлэн судлах хандлага ажиглагдаж буй нь манай сэтгүүл зүй судлал дахь шинэлэг хандлага, талархан дэмжүүштэй эхлэл мөн. Гуравдугаарт, манай орны сургалт, судалгааны томоохон төвүүд болох МУИС, МУБИС, МХХ, ХУИС зэрэг дөрвөн гол байгууллагын залуу судлаачдын шилмэл бүтээлүүд орсон нь аль байгууллага ямар "школ"-той, орчин үеийн сэтгүүл зүйн аль

асуудалд түлхүү анхаарч, сэтгүүл зүйн философийн талаар ямар үзэл баримтлалыг голлон барьдаг вэ гэдгийг мэдэрч, зохих дүгнэлт хийж, үнэлэлт өгөх боломжтой байна. Энэ бол тус номын нэг онцлог, давуу тал гэж ойлгож болно.

Номын сэдвийн хүрээ өргөн, ярилцлага, эссе, зураглал зэрэг бичлэгийн зүйлүүдээс эхлээд орчин үеийн Монголын сэтгүүл зүйн шинэ чиглэлүүд болох Интернет сэтгүүл зүй, иргэний сэтгүүл зүй, ОНМХ-ийн реклам сурталчилгаа, олон нийттэй харилцах буюу PR, улс төрийн сэтгүүл зүй, спортын сэтгүүл зүй, цаашлаад сэтгүүл зүйг бүхэлд нь хамарсан ОНМХ-ийн эрх зүйн зохицуулалт, мэдээллийн нийгмийн төлөвшлийн асуудал, ардчиллыг хөгжүүлэхэд чөлөөт хэвлэлийн үзүүлэх нөлөө, хэвлэлийн эрх чөлөөний тулгамдсан асуудал, сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлага, сэтгүүлчийн ёс зүй, хариуцлага, иргэний мэдэх эрх ба төрийн нууцын зохицуулалт, сэтгүүлчийн ур чадвар, нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга хүртэлх сэтгүүл зүйн онол, практик, арга зүйн бүхий л асуудлыг хамарсан нь эл бүтээл мэдээллийн багтаамж сайтай, танин мэдэхүйн ач холбогдол үнэхээр өндөр болсныг харуулах баримт мөн. Нөгөө талаар ийм залуу судлаачдын судалгааны бүтээлүүдийг нэгтгэж нэг боть

болгон гаргасан нь мэргэжлийн ангийн оюутнууд, магистрант, докторантууд болон сэтгүүл зүй судлаачид сонирхсон асуудлын талаарх мэдээлэл, баримтыг нэг дороос олж авах боломж бүрдүүлж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Б.Болд-Эрдэнийн орчин сэтгүүл зүйн онол, практикийн асуудлуудыг хөндсөн 14 өгүүлэл багтжээ. Б.Болд-Эрдэнэ хэдийгээр нас залуу боловч манай туршлагатай судлаачдын тоонд зүй ёсоор багтдаг хийсэн юмтай, хэлэх үгтэй, хийж бүтээе гэсэн хүсэл тэмүүлэлтэй, тодорхой зорилготой судлаач мөн. 1995 онд Болгарын хамгийн нөлөө бүхий сургуулийн нэг болох Софийн их сургуулийн сэтгүүлчийн ангийг сэтгүүл зүйн магистрын зэрэгтэй төгсөж ирээд МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимд багшилж эхэлснээс хойш миний бие түүний докторын ажлыг удирдан хамгаалуулж, олон ном, бүтээлийг хянан найруулж, хамтран өгүүлэл бичиж, илтгэл хэлэлцүүлж байсны хувьд «хэний хэн бэ» гэдгийг сайн мэднэ. Түүний бичсэн 10 орчим сурах бичиг, нэг сэдэвт зохиолын дотор «Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл» (1999), «Олон нийтийн харилцаа» (2007), «Интернет сэтгүүл зүй» (2009) зэрэг судалгааны томоохон бүтээлүүд манай сэтгүүл зүйн судлалд хүндтэй байр эзэлдэг. Судлаач Б.Болд-Эрдэнэ сэтгүүл зүйн аливаа асуудлыг авч үзэхдээ нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, ялангуяа улс төрийн тогтолцооны онцлогтой холбон тайлбарлаж, асуудлын мөн чанар, учир утгыг өргөн хүрээнд харж, гүн ухааны өнгө аястай, шинэлэг дүгнэлт хийхийг оролддогоороо бусад залуу судлаачаас ихээхэн ялгардаг. Энэ номд орсон бүтээлийн ихэнх нь дээрх онцлогийг агуулсныг амархан ажиглаж болно. Ялангуяа мэдээллийн тэнцвэрт байдал, чөлөөт хэвлэлийн төлөвшил, мэдээллийн нийгмийн мөн чанарын тухай бичигдсэн өгүүлүүдэд

хийсэн дүгнэлт, санал зөвлөмж нь Монголын нийгмийн хөгжлийн өнөөгийн тулгамдсан асуудлуудаас урган гарсан нь анхаарал татахуйц болжээ. Зохиогчийн аль ч өгүүллээс түүний онолын сэтгэлгээ, аливаа шинэ сэргэг зүйлийг мэдрэх чадвар сайн байгаа нь ажиглагддаг. Энэ бол судлаач хүнд байдаг чухал чанар гэдгийг онцлон хэлье.

Судлаач орчин үеийн сэтгүүл зүйн нэг гол зарчим болох мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах зарчмын үнэ цэнэ, мөн чанар, ач холбогдлын талаар дэлэрэнгүй өгүүлж, манай олон нийтийн мэдээллийн аль ч хэрэгсэлд мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж байгааг тодорхой жишээ баримтад тулгуурлан гаргахын зэрэгцээ түүний сөрөг үр дагаврын талаар “Мэдээллийн тэнцвэрт байдал нь нийгмийн мэдээллийн харилцаа эрүүл саруул байж, нийгмийн бүлэг, давхарга, хүчний эрх ашиг сонирхлыг бүрэн дүүрэн илэрхийлнэ гэсэн үг юм. Мөн нийгмийн амьдралын асуудал, үйл явдал, үзэгдлийн учир шалтгаан, үнэн мөнийг нээж, хэвлэл мэдээлэл чөлөөт байхын утга учир, нийгмийн оюун санаа, сэтгэл зүйд бодитой байр суурь эзэлнэ гэсэн үг юм. Харин өнөөдөр энэхүү чөлөөт хэвлэлийн утга учир, зорилго бидэнд үгүй байна” (114 дэх тал) гэсэн дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Мөн хэвлэлийн чөлөөт байдал, олон ургальч үзэл, ил тод байдал адагдахад хүрч байгаа гол хүчин зүйлийг нөлөө бүхий хэвлэл мэдээллийн өмчлөлтэй холбон тайлбарласан нь зөв зүйтэй бөгөөд “Мэдээллийн нөлөө байр суурь нийгмийн амьдралд онцгой чухал болохын хирээр хэрэгслийн эзэмшил хяналт эрх мэдэл, хөрөнгө чинээ бүхий явцуу цөөн тооны хүмүүсийн гарт төвлөрч байна. Энэхүү явцуу хүрээнд үйлчлэх зорилготой, мэдээллийн технологийн хөгжилд тулгуурласан хэрэгслийн төвлөрөл нь ардчиллын үнэлэмжийн тулгуур болох эрх чөлөөтэй байх, өмчтэй байх, үзэл бодолтой байх зэрэг хувь хүний

бие даасан, эрх мэдэлтэй, эрхэмлэн дээдлэгдэх үзэл баримтлалыг саармагжуулж байна. Хувь хүнийг дээдлэх үзлийн нөлөө байр суурь хумигдахын хирээр мэдээллийн хэрэгслийн нийгмийн үнэнийг мэдэх, ардчиллын үнэлэмжийг төлөвшүүлэх, ургальч байдлыг хөхүүлэн дэмжих зэрэг үүрэг хариуцлага алдагдах аюулд хүрээд байна" (125 дахь тал) гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм.

Тус номд чухал байр эзэлж байгаа бүтээлүүд бол манай залуу судлаач, МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхмийн багш, сэтгүүл зүйн доктор, дэд профессор Ч.Чойсамбын судалгааны өгүүллүүд мөн. Судлаач Ч.Чойсамба манай залуу судлаачдын дотор хамгийн хөдөлмөрч, хамгийн бүтээлч эрдэмтэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. 1997 оноос Сэтгүүл зүйн тэнхимд багшилж, энэ хугацаанд нэг сэдэвт зохиол, судалгааны ном, орчуулгын бүтээл 20 гаруйг бичиж хэвлүүлсэн нь үүний тод жишээ юм. Судлаач Ч.Чойсамба аливаа бүтээлд нягт нямбай хандаж, найруулгын маш өндөр төвшинд боловсруулж, "долоо хэмжиж нэг огтолдог" уран бүтээлч мөн. Үүнийг түүний аль ч бүтээлээс ажиглаж, мэдэрч болно. Ч.Чойсамба сэтгүүл зүйн практик, арга зүйн асуудалд түлхүү анхаарч, сэтгүүлчийн ёс зүйн алдаа, нийтлэл нэвтрүүлгийн хэл найруулга, бичлэгийн төрөл зүйл, экологийн сэдэвт нийтлэл, нэвтрүүлгүүдийн онцлогийг голлон судалдаг. Түүний бүтээлүүд үнэлэлт дүгнэлт, чанар чансаа, шинэлэг санаа, танин мэдэхүйн ач холбогдлоороо ямагт уншигч, хүлээн авагчдын талархлыг хүлээдэг. Үүний тодорхой жишээ бол судалгааны бүтээлээрээ МСНЭ-ийн нэрэмжит шагнал, ШУА-ийн алтан медаль хүртсэн явдал юм. Эл номд орсон Ч.Чойсамбын бүтээлүүд сэтгүүлчийн ёс зүйн болон хэл найруулгын алдаа, дутагдлыг тодорхой жишээ баримтад тулгуурлан гаргаж, түүнийг арилгах арга замын талаар үнэтэй

санал зөвлөж дэвшүүлснээрээ онцлогтой болжээ. Залуу судлаач өнөөдөр манай сэтгүүл зүйн үйл ажиллагаанд хамгийн их дутагдаж буй хэвлэл мэдээллийн ажилтнуудын ҮЭ-ийн шаардлага, ач холбогдлын талаар асуудал дэвшүүлсэн өгүүлэлдээ "...сэтгүүлчид эзнийхээ гарт зэмсэг л болсон. Сэтгүүлчид нийтлэлийн бодлогыг тодорхойлох эрхгүй. Сэтгүүлчид редакцид ямар ч эрх мэдэлгүй. Эрүүл мэнд, амь насаараа дэнчин тавин байж олж ирсэн мэдээллийг нь эзэн нь сонирхсон нэгэнд худалдаж, ашиг олно. Хэнийг магтах, тэгэхдээ бүр юу гэж магтахыг, хэнийг шүүмжлэх, тэгэхдээ бүр юу гэж шүүмжлэх ёстойг нь заана. Үүнийгээ редакцийн бодлого гэнэ. Энэ редакцийн бодлоготой нь тэрсэлдсэн хэнийг ч болов гудамжинд хөөгөөд гаргана. Түүнийг ажил төрөлд орвол араас нь утасдаж, ажил олгогчтой нь ярьж, халахыг зөвлөнө. Санасандаа ч хүрнэ. Энэ бүхний эцэст дүгнэн хэлэхэд Монголын сэтгүүлчдэд эрх ашгийг нь хамгаалдаг ҮЭ хэвлэлийн эрх чөлөөнөөс илүү хэрэгтэй байна" (329 дэх тал) гэсэн дүгнэлт хийсэн нь үнэхээр анхаарч үзүүштэй чухал санаа юм. Мөн судлаач Ч.Чойсамба манай цахим сэтгүүл зүй дэх шинэ үзэгдэл болох блог болон блогчдын тухай сонирхол татахуйц өгүүлэл бичсэн байна. Эл өгүүлэл блог бол иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэх нэг чухал хүчин зүйл мөн гэдгийг онцлон тэмдэглэж, «Блоггерууд Интернет хэмээх мэдээллийн даяарчлагдсан орон зайд "аж төрдөг", энэхүү оройн зайн өвөрмөц хуулийг дагаж мөрддөг. Энэхүү орон зай нь бодит амьдралтай нягт уялдан сүлжилддэг учир блог хөтлөлт нь энгийн нэг хоббиноос хүмүүсийн ухамсарт нөлөөлдөг үйл ажиллагаа болоод байна» (330 дахь тал) гэсэн сонирхолтой, анхаарч үзүүштэй дүгнэлт хийжээ. Цаашид блог орчин үеийн нийгэмд харилцааны, өөрийгөө илэрхийлэх, нийгмийн холбоог бэхжүүлэх хадгалах, дурдатгалын,

өөрийгөө хөгжүүлэх, сэтгэл зүйн эмчилгээний үүргийг гүцэтгэдэг зэрэг шинэ санаа, шинэлэг дүгнэлт хийсэн нь анхаарал татах асуудал мөнөөс мөн.

Сүүлийн жилүүдэд практик сэтгүүл зүйн, түүний дотор нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, ур чадварын асуудалд түлхүү анхаарч, «Сэтгүүл зүй» (2007), «Практик сэтгүүл зүй» (2010), «Суурь сэтгүүл зүй» (2011) зэрэг практик ач холбогдол өндөр, сонирхолтой, өгөөж сайтай сурах бичиг, гарын авлага бичсэн судлаач бол МУБИС-ийн сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Ж.Батбаатар юм. Судлаач Ж.Батбаатар сэтгүүлчийн ур чадвар, бичлэгийн тодорхой төрөл, зүйлүүдийн бичлэгийн арга барил, онцлог, хэл найруулга, нийтлэл, нэвтрүүлэг бүтээх үе шатуудын онцлогийг тусгасан өгүүллүүдийг багтаасан нь ирээдүйн сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад ажиллаж буй залуу сэтгүүлчид, сэтгүүл зүйн бус мэргэжилтэй уран бүтээлчдэд чухал ач холбогдолтой болжээ. Нөгөө талаар сэтгүүлчдийн үйл ажиллагаанд болон тэдний бичсэн бүтээлд оршиж буй алдаа, дутагдлыг тодорхой жишээ баримтуудаар тайлбарласан нь бүтээлүүдийн үр өгөөжийг дээшлүүлж, уншууртай, сонирхолтой болсныг тэмдэглэж байна. Судлаач Ж.Батбаатар зар сурталчилгаа, PR-ын ялгаатай болон нийтлэг талын талаар бичсэн өгүүлэл нь дэвшүүлж буй асуудлын үндэслэл, гаргалгаа, дүгнэлтийг хувьд анхаарал татахуйц болжээ. Судлаачийн "Манай практикт зар сурталчилгаа, сэтгүүл зүй зэрэг өөр салбаруудтай адилтгасан, хольж хутгасан PR үйл ажиллагааны "монголчилсон" хэв маяг дэлгэрч, түүнийг гүтгэн гүжирдэх, гутаан доромжлох бохир хэрэглүүр болгон ашиглаж хэвшсэнээр олон нийтэд ч ихээхэн буруу ташаа ойлголт бий болжээ. Улмаар хэн нэгнийг муулах, гутаах аргаа хар PR, худал магтан дөвийлгөхөө цагаан PR гэж хүртэл хуваан, мэдлэгийн энэхүү

салбарыг буруу зорилгоор, зөвхөн явцуу ашиг сонирхолын хүрээнд хэрэглэж ирсний уршгаар PR хэмээх нэр томьёо нь "хадны мангаа" гэдэгтэй дүйх шахам утга илэрхийлэх болсон нь олон нийтийн харилцааны хөгжил, төлөвшилд ихээхэн сөрөг үр дагавар авчирч байна" (28 дахь тал) гэдэгтэй сэтгүүл зүйн судлаач хүний хувьд санал нэг байна. Харин эссегийн тухай өгүүлэл дэх зарим санаа, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай болсон гэдгийг хэлэх хэрэгтэй. Тухайлбал, "Эсээ нь сэтгүүл зүйн бичлэгийн бие даасан нэгэн төрөл болохоос гадна редакцийн өгүүлэл, номын болон киноны шүүмж, өдрийн юм уу, долоо хоногийн үйл явдлын тойм, аян замын тэмдэглэл зэрэг бусад төрөл зүйл, бүр зарим захидал ч хүртэл эсээний шинжийг агуулж байх нь түгээмэл билээ" (42 дахь тал). "Манай сэтгүүлчид, эсээ бичигчдийн бүтээлээс Л.Түдэвийн эсээнүүд сонгодог утгаараа эсээний хэв шинж, өнгө төрхийг илүүтэй илэрхийлж чаддаг. Түүний "Нью-Йорк урт чацтай хот" бүтээл цуврал эрхин эсээний шинжтэй юм" (46 дахь тал) гэсэн дүгнэлтийг сэтгүүл зүйн онолын үүднээс авч үзвэл асуудалд хэт өнгөцхөн хандсан, сэтгүүл зүйн зарим бичлэгийн төрөл, зүйлүүдийн үндсэн шинж, дотоод хэлбэр, зорлгыг арай дутуу дулимаг судалсан мэт сэтгэгдэл төрөхөөр байна. Ер нь орчин үеийн сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн хөгжлийн нэг гол хандлага бол хоорондоо уусах, нэг нь нөгөөгийн шинжийг тодорхой хэмжээгээр агуулах явдал юм. Тиймээс нэг бичлэгийн төрөл өөр бичлэгийн зүйлүүдийн шинжийг агуулах нь энгийн үзэгдэл гэж ойлгож болно. Нөгөө талаар сэтгүүлчийн үзэл бодол орсон бол эссэгийн шинж гэж үзэх үндэслэлгүй. Угаасаа шүүмж, редакцийн өгүүлэл, тойм зэрэг бичлэгийн зүйлүүдийг зохиогч өөрийн үзэл бодол, үнэлэлт дүгнэлт, тайлбарыг оруулахгүйгээр бичих боломжгүй юм. Зохиолч, сэтгүүлч Л.Түдэвийн

наяад оны дунд үед бичигдэж, олны талархлыг хүлээж, судлаачдын хараанд өртөж байсан "Нью-Йорк урт чацтай хот" бүтээл нь аян замын тэмдэглэл ба аян замын найрууллын зааг дээр оршдог шилдэг нийтлэл бөгөөд эрхин эссэ гэж дүгнэх үндэслэлгүй юм. Хэрэв ийм бүтээлийг эссэ гэж үзвэл Монголын тогтмол хэвлэл дэх нийтлэл-уран сайхны бүх бичлэгийн зүйлийг эссэ гэж нэрлэхэд хүрэх болно.

Манай сэтгүүл зүйн эмэгтэй эрдэмтэн судлаачдын дотор сургалт-судалгааны чиглэлд идэвх санаачилгатай ажиллаж, багагүй бүтээл туурвиж буй залуу эрдэмтэн бол Д.Дагиймаа мөн. Тэрбээр ОНМХ-ийн реклам сурталчилгааг дагнан судалж, сэтгүүл зүйн магистр, докторын зэрэг хамгаалсан бөгөөд сүүлийн жилүүдэд энэ сэдвээр "Зар сурталчилгааны үндэс", "Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх зар сурталчилгаа" зэрэг сонирхолтой ном хэвлүүлсэн юм.

Энэ номд ч Д.Дагиймаа өөрийнхөө нарийн мэргэшсэн асуудлын хүрээнд ОНМХ дэх нийгмийн рекламн талаар баримт мэдээлэл, үнэлэлт дүгнэлт, үр өгөөж сайтай өгүүллээ нийтлүүлжээ. Судлаач дээрх сэдвээр бичигдсэн судалгааны томоохон өгүүлэлд нийгмийн рекламн үүсэл хөгжил, мөн чанар, онцлог, үүрэг зорилго, ангилал, нийгмийн реклам ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн хоорондох харилцан уялдаа холбоо, нийгмийн рекламн ур чадварын асуудлыг судалж, манай ОНМХ дэх нийгмийн рекламн агуулга, хэлбэр, ур чадварт оршиж буй алдаа дутагдлыг гаргахыг оролдсон нь нэн сайшаалтай юм. Энэ бүхний үр дүнд

судлаач: "Гаднын орнуудад нийгмийн реклам бэлтгэхийн өмнө түүний шалгуурыг юун түрүүнд харгалзан үздэг. Тэгвэл манайд нийгмийн рекламд гэлтгүй бүх төрлийн сурталчилгааг бэлтгэхдээ судалгааг үл ойшоох тал анзаарагддаг. Зорилтот хэрэглэгчид, тэдгээрийн онцлог, хэвлэл, мэдээллийн ямар хэрэгслийг сонговол зохимжтой вэ зэргийг судалж, мэдэлгүйгээр реклам бүтээх нь хамгийн эрсдэлтэй бөгөөд ажлын үнэ цэнийг алдагдуулдаг" (207 дахь тал) гэсэн анхаарч үзүүштэй дүгнэлтэнд хүрчээ.

МХХ-ийн захирал, доктор М.Мөнхмандах ОНМХ-ийн эрх зүйн зохицуулалт, чөлөөт хэвлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудалд гол анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр бичигдсэн хэд хэдэн өгүүллээ эл номд оруулжээ. Ялангуяа иргэний мэдэх эрх, төрийн нууцын зохицуулалт, олон нийтийн телевизийн талаар бичигдсэн өгүүлэлд дэвшүүлсэн санал зөвлөмж, хийсэн үнэлэлт дүгнэлт анхаарал татахуйц болжээ. Судлаачийн "Улс төрчдийн чихэнд уях хонх буюу олон нийтийн телевизийн тухай эргэцүүлэхүй", "Олон нийтийн телевизийн тодорхойлолт хууль дүрмийн төсөлд" зэрэг өгүүлэлд олон нийтийн телевизийн онцлог шинж, үйл ажиллагааны чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын асуудлуудыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл сайн хөгжсөн орнуудын жишээн дээр тайлбарласан нь шинэ тутам хөгжиж буй манай орны олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, нэвтрүүлгийн чанарыг сайжруулахад чухал ач

«

*Залуу судлаачдын бүтээлүүдийг
бүхэлд нь авч үзэхэд орчин үеийн
сэтгүүл зүйн судлалд түгээмэл
ашигладаг харьцуулан судлах,
нэгтгэн дүгнэх, агуулгын дүн
шинжлгээ, логикийн болон
түүхчлэн үзэх, социологийн
судалгааны аргуудыг аль болох
түлхүү ашиглахыг оролдсон нь
дэмжүүштэй хандлага юм.*

»

холбогдолтой болжээ. Судлаач "Ардчилал хөгжсөн ихэнх орон яадаг ч байсан ямар нэгэн хэлбэрээр "олон нийтийн" радио телевизтэй байх гээд зүтгээд байдаг нь цаанаа учиртай. Тэр нь юу вэ гэвэл, ардчилал зах зээлийн чөлөөт байдал хөгжихийн хэрээр нийгэм задарч, нэгдмэл шинж чанар нь сулардаг тул улс төр, эдийн засаг, соёл урлаг, оюуны амьдралын бүхий л салбарт аливаа туйлшралаас зайлсхийж, тэнцвэрт байдлыг хадгалахын үүднээс хамгийн хүчтэй зэвсэг болох электрон мэдээллийн хэрэгслийг олон түмний эрх ашгийн "манаанд" тавьж, үйл ажиллагааных нь чиг баримжааг тодруулж өгдөг" (221 дэх тал) гэж дүгнээд олон нийтийн радио, телевиз нь иргэдийг суурь мэдээллээр хангаж, оюуны үнэт зүйлсийн чиг баримжааг бий болгосноор нийгмийн зөвшилцөл, нэгдмэл байдлыг хадгалахад хувь нэмэр оруулах, нийгмийн бүх давхарга, хэсэг бүлгийнхэн адил тэгш эрхтэйгээр өөр хоорондоо үзэл бодлоо солилцох боломжоор хангах, сэтгүүл зүйн болон уран сайхны хэм хэмжээг баримталж, үлгэх дууриалал үзүүлэх, оюуны эрэлт, нийгмийн шаардлагын үүднээс хэрэгцээтэй боловч зах зээлийн ойлголтоор "ашиггүй" нэвтрүүлгийг ч бэлтгэж тухайн цөөнхийн хэрэгцээг харгалзан мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах зэрэг үүргийг санал болгожээ. Доктор М.Мөнхмандахын бүтээлүүдэд ийм шинэ санаа, шинэлэг дүгнэлт олон байгааг тэмдэглэх хэрэгтэй. Гэхдээ судлаачийн зарим өгүүлэл нь судалгааны бүтээл гэхээсээ илүү өдөр тутмын сонин, сэтгүүлд зориулж бичсэн санал бодол, сэтгэгдэл төдий зүйл байгаа нь ажиглагдлаа.

Залуу судлаачдын бүтээлүүдийг бүхэлд нь авч үзэхэд орчин үеийн

сэтгүүл зүйн бүхий л асуудлыг хамарсан, аливаа асуудалд өөр өөр өнцгөөс харж, өөр өөр арга барилаар хандаж боловсруулсан шинэлэг тал ажиглагдлаа. Мөн орчин үеийн сэтгүүл зүйн судлалд түгээмэл ашигладаг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх, агуулгын дүн шинжилгээ, логикийн болон түүхчлэн үзэх, социологийн судалгааны аргуудыг аль болох түлхүү ашиглахыг оролдсон нь дэмжүүштэй хандлага юм.

Энэ номын өөр нэг чухал ач холбогдол нь залуу судлаачдын бүтээлүүдийг олны хүртээл болгон сурталчлан таниулахын хамт сэтгүүл зүйн судлалын хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар тодорхой төсөөлөл олж авахад оршино.

Судалгааны бүтээлүүдэд энэ мэтийн ололт амжилт, олзуурхан тэмдэглүүштэй зүйл байгаа боловч цаашид анхаармаар, дараа дараагийн бүтээлүүдэд засаж залруулмаар зүйл ч цөөнүй байна. Судалгааны бүтээл гэхээсээ илүү сэтгүүл зүйн нийтлэлийг санагдуудаг. Номд орсон янз бүрийн сэдвээр, янз бүрийн төвшинд бичигдсэн бүтээлүүд өнөөдрийн Монголын сэтгүүл зүйн судлалын бүх асуудлыг хамарч, бүрэн дүүрэн үнэлэлт өгч, дүгнэлт хийж чадаагүй нь ойлгомжтой боловч тодорхой мэдээлэл өгч чадна гэдэгт итгэлтэй байна.

Резюме

Настоящая рецензия посвящена исследовательским работам молодых учёных, преподающих в ВУЗ-ах страны по специальности журналистика, которые включены в 77-й том 99-томного издания "Избранное монгольских публикаций", учредителем которого являются Союз монгольских журналистов.